



УВС ХҮНС ХК



9001:2015

2019

ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

1 КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

2 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3 НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

4 САНХҮҮГИЙН ТАЙЛАН



УВС ХҮНС ХК

КОМПАНИЙН ТУХАЙ



КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1942 онд улсын үйлдвэрийн газар болон байгуулагдаж хүн амыг хүнсээр хангах үйлдвэрлэл явуулж эхэлсэн.

1998 оноос “УВС ХҮНС” ХК болон зохион байгуулагдаж хүнсний өргөн нэр төрлийн бараа үйлдвэрлэдэг орчин үеийн компани болон хөгжиж байна.

2006 онд дотоод хяналтын лабораторын үйл ажиллагаанд MNS 17025 стандарт нэвтрүүлж итгэмжлэгдсэн лабораторитой болсон.

2009 оноос чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоо ISO 9001:2008 стандартыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, баталгаажуулсан.

2018 онд чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоо ISO 9001:2015 стандарт, хүнсний аюулгүй байдлын HACCP стандарт, чацарганы аж ахуйд хөдөө аж ахуйн зохистой дадал GAP стандартуудыг нэвтрүүлэн ажиллаж байна.

Манай компани экологийн цэвэр нөөцийг дэвшилтэт технологиор боловсруулан эрүүл хүнсийг бүтээн хэрэглэгчдэд хүргэх эрхэм зорилгодоо хүрэхийн тулд хүнсний аюулгүй байдлын тогтолцоог байгууллагадаа нэвтрүүлэн хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулалт хийж ажиллах чанарын бодлоготой ажилладаг.





УВС ХҮНС ХК

*Шүүдэр мэт цэвэр
Гал мэт ариун
Тэнгэр мэт хязгааргүй...*

Эрүүл хүнс Аз жаргалын эхлэл

<i>Алсын хараа</i>	Дэлхийд хүндлэгдсэн "Made in Mongolia"-г бид бүтээнэ				
<i>Эрхэм зорилго</i>	Экологийн цэвэр нөөцийг дэвшилтэт технологиор боловсруулан эрүүл хүнсийг бүтээж, хэрэглэгчдэд хүргэнэ.				
<i>Члэт зүйлс</i>	Экологийн цэвэр орчин	Хүний нөөц	Өөрсдийн бүтээсэн технологи	Хэрэглэгч	
<i>Баримтлах зарчим</i>	Шударга байдал	Ёс зүй, хүндлэл	Зөв хандлага	Хариуцлага	Хөгжүүлэгч



УВС ХҮНС ХК

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019 оны бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хийгдсэн ажлууд



ISO 9001-2015 Чанарын Удирдлагын Тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд Чацаргана боловсруулах үйлдвэрт урсгал засвар хийж, тоног төхөөрөмжийн шинэчилэл хийв.

2019 оны 9-р сард ХБНГерман улсын талх нарийн боовны мэргэжилтэнг MR.Koop Andreas манай үйлдвэрт 2 дахь жилдээ хүрэлцэн ирж сургалт явуулж шинээр 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэн худалдаанд гаргалаа.



500 мл савлагаатай “Увсын чацаргана” чацарганы өтгөрүүлсэн шүүсний савлагаа шинэчилж худалдаанд гаргав.

2019 онд “Увсын чацаргана” чацарганы өтгөрүүлсэн шүүсний савлагааг 340 мл болгон шинэчилэн савлаж худалдаанд гаргав.



Чацарганы үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийн хүрээнд 35 мл савлагааны шинэ тоног төхөөрөмжийг ашиглалтанд оруулж 35 мл савлагаатай Чацарганы шүүс худалдаанд гаргалаа.

2019 оны бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хийгдсэн ажлууд



Чацарганы бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх мөн хэрэглэгчдийн санал хүсэлтэд тулгуурлан дархлаа дэмжих чацаргана жимсний амин дэм, витаминлаг чанарыг бүрэн агуулсан чацарагны чанамал шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэн худалдаанд гаргалаа.

Найрлагадаа омега 3, омега 6 бодисыг агуулаж байдаг нөхөн төлжүүлэх, сэргээх чадвар нь шинжлэх ухаанаар батлагдсан жимснээс гаргаж авч болох хамгийн сайн чанарын тос болох чацарагны үрийн тос. Хэрэглэгчдэд зориулан хэрэглэхэд хялбар савлагаатай болгон өөрчилж худалдаанд гаргалаа



Чацаргана жимсний зөөлөн эдээс гарган авдаг чацарганы 100% цэвэр тосны савлагааг шинэчилж худалдаанд гаргалаа.



УВС ХҮНС ХК

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Компанийн нийгмийн хариуцлага



Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд “Хүүхэнд бүр жаргалтай байг” арга хэмжээг зохион байгуулж цэнгэлдэх хүрээлэнд хүрэлцэн хүүхэд бүрт Увс Хүнс ХК-ийн бүтээгдхүүнийг үнэ төлбөргүй амтлах үзэсгэлэнг зохион байгууллаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Увс түншлэл - 2019” үндэсний үйлдвэрлэлийн шилдэгүүдийг тодруулдаг “Увс Түншлэл” үзэсгэлэнгийн шилдэгийн шилдэг “Гранпри” шагнал хүртлээ.



Шинэ он шинэ жилийн баярыг тохиолдуулан Манай компаниатай хамтран ажилладаг Шилдэг харилцагч байгууллагууд болон худалдаа эрхлэгч нарт гарын бэлэг гарлууллаа.

Компанийн нийгмийн хариуцлага

Энэ жил Чацарганы ургац хураалтанд нийт 200 гаруй хүнийг түр ажлын байраар ханган ажиллуулж 40 гаруй тн жимс хураан авлаа.



Чацарганы ургац хураалтын үеэр манай компанийн үйл ажиллагаа болон чацарганы жимсны ургац хураалттай танилцахаар Улаанбаатар хотын "Шинэ эрин" сургуулийн ахлах ангийн сурагчид 2 дахь жилдээ хүрэлцэн ирлээ. Энэ хугацаанд сурагчид "Увс хүнс" ХК-ийн үйл ажиллагаатай танилцах болон баруун монголын ард түмний ёс заншил мөн манай компанийн 100 га чацарганы плантацид очиж чацаргана хураалттай танилцаж мөн өөсдийн биеэр чацаргана хураалтад оролцлоо.





УВС ХҮНС ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН /мян.төг/	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Бараа материал	879,871.00	1,120,985.15
Урьдчилж төлсөн төлбөр	109,838.68	150,736.30
Дансны болон бусад авлага	783,855.85	773,776.14
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	20,383.85	12,470.61
Нийт эргэлтийн хөрөнгө	1,793,949.38	2,057,968.20
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,862,729.74	1,802,703.32
Биет бус хөрөнгө	-	12.44
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Нийт эргэлтийн бус хөрөнгө	1,862,729.74	1,802,715.76
Нийт хөрөнгө	3,656,679.12	3,860,683.96

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН /мян.төг/	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ		
Дансны өглөг	860,555.10	910,856.73
Цалингийн өглөг	18,888.27	18,261.98
Татварын өглөг	204,353.14	414,675.34
НДШ - ийн өглөг	381.68	1,872.07
Богино хугацаат зээл	415,000.00	286,042.42
Хүүний өглөг	3,076.44	3,122.71
Урьдчилж орсон орлого	12,678.15	0
Богино хугацаат өр төлбөр	158,260.01	258,280.31
Нийт богино хугацаат өр төлбөр	1,673,192.80	1,893,111.56
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Урт хугацаат зээл		
Нийт урт хугацаат өр төлбөр		
Нийт өр төлбөр	1,673,192.80	1,893,111.56
ӨМЧ		
Хувьцаат капитал	14,736.73	14,736.73
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	847,420.49	847,420.49
Хуримтлагдсан ашиг	1,121,329.11	1,105,415.18
Нийт өмч	1,983,486.33	1,967,572.40
Нийт өр төлбөр ба өмч	3,656,679.12	3,860,683.96

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН /мян.төг/	2019 он төгрөг	2018 он төгрөг
Борлуулалтын орлого	2,445,612.02	2,482,800.58
Борлуулалтын өртөг	1,543,741.22	1,502,876.21
Нийт ашиг	901,870.80	979,924.38
Ерөнхий ба удирдлагын зардал	868,311.99	699,013.22
Үндсэн үйл ажиллагааны ашиг	33,558.81	280,911.16
Хүүний орлого	1,183.30	-
Бусад орлого	1,349.35	12,242.81
Бусад зардал	19,062.83	3,964.25
Гадаад валютын ханшийн зөрүүний олз / гарз	653.50	(328.56)
Татвар төлөхийн өмнөх ашиг	17,682.14	288,861.15
Орлогын татварын зардал	1,768.21	14,443.06
Тайланг жилийн цэвэр ашиг	15,913.93	274,418.10

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО /СаяТ/



ЦЭВЭР АШИГ /СаяТ/





УВС ХҮНС ХК

КОМПАНИЙН СОЁЛ ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛТ

Компанийн соёл, хүний нөөцийн өсөлт хөгжилт

Увс Хүнс ХК-ийн нийт ажилтануудын тоо 2019 оны 12- сарын 31 - ний байдлаар 76 бөгөөд нийт ажилчдын 61% -ийг эмэгтэй, 39% - ийг эрэгтэй ажилчид бүрдүүлж байна. Бид Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг ажилдаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 1-р сарын 16 нд Германы DQS олон улсын аудитын байгууллага манай компани дээр аудит хийхээр төлөвлөгдөөд байна.



76

НИЙТ АЖИЛЧДЫН ТОО



46

Эмэгтэй ажилтан



30

Эрэгтэй ажилтан



35

Ажилтнуудаа хамруулсан сургалтын тоо



140

Сургалтын цаг



320

Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо /Давхардсан тоогоор/



14

Шинэ ажилтны чиглүүлэх сургалт



Ажилчдынхаа эрүүл мэндэд анхаарч, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үүднээс 7 хоног бүрийн /Лхагва гарагт спорт зааланд тоглодог. Байгууллагын аварга шалгаруулах спортын тэмцээнийг жил бүр уламжлал болгон зохион байгууладаг.

Ажилчдынхаа амьдрал ахуй гэр бүлийг нь дэмжин туслах үүднээс шинээр гол голомтоо бадрааж байгаа гэр бүлд компаний зүгээс мөнгөн урамшуулал мөн шинээр төрсөн бяцхан үрсэд хадгаламжийн дэвтэр нээж өгдөг уламжлалтай.



Ажилчдын эрүүл мэндийг дэмжих үүднээс нийт ажилчдад өдрийн хоолоор үйлчилдэг.





www.uvsfoods.mn



YBC XYHC XK



Info@Uvsfoods.mn



(976)-7555-8686